



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар A/191

Булган


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын X хуралдааны 10/06 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Агт сумын Хануй, Цагаан голын рашаан, сувиллын газарт стандарт шаардлага хангасан боловсон жорлонгийн тойм судалгаа хийх ажлыг Хануй голын сав газрын захиргаа /Д.Бямбажаргал/-д даалгасугай.

2. Дээрх ажилд шаардлагатай 1 000 000 /нэг сая/ төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Сав газруудын талуудын оролцооны зөвлөлийн хурал, зөвлөгөөн” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

D:\ЗДТГ,ХОХБТХ\Захирамж

20190192